БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/121/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Баянхонгор<br>2024 оны 02 дугаар сарын 23 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Ахлах аудитор: М.Алтантуяа<br>Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитор: Н.Батчимэг<br>Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 2
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 6
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 11
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ..... 16
**4.1 Ерөнхий зүйл** ..... 16
**4.2 Материаллаг байдал** ..... 16
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ..... 17
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..... 17
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ..... 17
**4.5.1 Завсрын аудитын талаар** ..... 17
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 18
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 20

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| НББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/68

танай____________-ны № ______________ -т

ШИНЭЖИНСТ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Б.ХОРОЛМАА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн.
- Даргын 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн Б/14 дүгээр тушаалаар сумын эргэлтийн эмийн сангийн эрхлэгчээр ажилладаг, багийн бага эмч Х.Давааг аймгийн Эрүүл мэндийн газраас олгодог тендерийн эм хариуцсан ажилтнаар томилон ажил хавсарсны нэмэгдэлд 40 хувиар тооцон 1,686.6 мянга, мөн даргын 2023 оны 07 дугаар 03-ны өдрийн Б/23 дугаар тушаалаар угаагч Ш.Баасантогтоход ариутгагчийн ажлыг хавсран ажилласны нэмэгдлийг 40 хувиар олгохоор шийдвэрлэж 1,200.0 мянган төгрөгийг тус тус олгосон байна.
- Бараа материалын тайланд “Лхагүн” ХХК-иас худалдан авсан 5,670.2 мянган төгрөгийн бараа материалыг орлого авалгүйгээр шууд зардлаар тайлагнасан, мөн тайлант хугацаанд тус байгууллагын нярав нь тендерийн эмийн тайланг гаргасан боловч больницын эмийн тайланг гаргаагүй байна.

5020254

- Тайлант хугацаанд өмнөх оны 1,365.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг давхардуулан шилжүүлснээс нийгмийн даатгалын байгууллагад 6,793.4 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" гэсэн заалтууд, УСНББОУС-12 Бараа материал болон үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг барагдуулахдаа давхар шилжүүлж авлага үүсгэсэн, бараа материалыг шууд зардлаар тайлагнасан, шагналын суутгалыг суутгаагүй, ажил хавсран ажилласны нэмэгдлийг буруу олгосон, нийгмийн даатгалын мэдээг дутуу мэдээлсэн зэрэг нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Шинэжинст сумын Засаг дарга 90.0 хувь. Аймгийн Эрүүл мэндийн газраас 70.1 хувиар үнэлсэн байна. Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **256,051,558.84** | **195,171,628.67** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 89,156,563.55 | 38,676,064.74 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 89,156,563.55 | 38,676,064.74 |
| **3121** | **Төгрөг** | 89,156,563.55 | 38,676,064.74 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 89,156,563.55 | 38,676,064.74 |
| **33** | **АВЛАГА** | 1,365,236.34 | 14,844,451.53 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 895,816.92 | 7,689,229.11 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 00.00 | 6,685,803.00 |
| **335** | **Бусад авлага** | 469,419.42 | 469,419.42 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 469,419.42 | 469,419.42 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 165,529,758.95 | 141,651,112.40 |
| **351** | **Түүхий эд материал** | 109,280,590.02 | 87,280,945.47 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 20,557,089.00 | 20,557,089.00 |
| 35130 | Эм боох материал | 88,723,501.02 | 66,723,856.47 |
| **354** | **Хангамжийн материал** | 55,429,168.93 | 53,550,166.93 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,232,077.00 | 1,430,090.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 17,155,123.04 | 11,225,533.04 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,434,000.00 | 4,551,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,000,000.00 | 00.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,560,000.00 | 125,575.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 31,047,968.89 | 36,217,968.89 |
| 35600 | Мал амьтад | 820,000.00 | 820,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **765,765,201.49** | **729,220,075.41** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 765,765,201.49 | 729,220,075.41 |
| **392** | **Биет хөрөнгө** | 757,205,201.45 | 720,730,075.33 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 606,350,893.00 | 606,350,893.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -98,184,920.68 | -122,101,808.56 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 111,360,352.00 | 87,371,602.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -31,214,518.67 | -20,202,018.71 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 209,323,502.37 | 241,230,919.37 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -91,344,868.59 | -118,165,698.95 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 76,059,919.50 | 85,960,127.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -31,555,740.59 | -45,059,523.43 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 12,600,000.00 | 12,600,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -6,189,416.89 | -7,254,416.89 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 8,560,000.04 | 8,490,000.08 |
| 39301 | Програм хангамж | 800,000.00 | 800,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -519,999.96 | -589,999.92 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,280,000.00 | 8,280,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,021,816,760.33** | **924,391,704.08** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **21,456,193.10** | **165,652.70** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 21,456,193.10 | 165,652.70 |
| **413** | **Өглөг** | 21,456,193.10 | 165,652.70 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 21,290,540.40 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 165,652.70 | 165,652.70 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 165,652.70 | 165,652.70 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,000,360,567.23** | **924,226,051.38** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,000,360,567.23 | 924,226,051.38 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 734,316,565.92 | 734,316,565.92 |
| 51101 | Өмч: - төрийн | 734,316,565.92 | 734,316,565.92 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -88,044,481.11 | -164,178,996.96 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -88,044,481.11 | -88,044,481.11 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -76,134,515.85 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 354,088,482.42 | 354,088,482.42 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,021,816,760.33** | **924,391,704.08** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **791,778,573.45** | **666,987,414.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **165,963,926.45** | **28,660,110.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 165,963,926.45 | 28,660,110.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **625,814,647.00** | **638,327,304.50** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 29,439,100.00 | 35,728,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 29,439,100.00 | 35,728,400.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 596375547.00 | 602598904.50 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 596,375,547.00 | 602,598,904.50 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **639,503,870.90** | **740,646,930.35** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **639,503,870.90** | **740,646,930.35** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 633,290,967.90 | 731,781,473.35 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 307,281,504.66 | 392,020,512.88 |
| 210101 | Үндсэн цалин | 307,281,504.66 | 256,452,893.82 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 112,102,844.44 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 23,464,774.62 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 39,360,662.45 | 47,534,704.84 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,019,296.79 | 31,587,218.72 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,149,366.41 | 3,995,571.53 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,626,150.19 | 3,187,658.22 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 663,725.24 | 795,113.31 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,902,123.82 | 7,969,143.06 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,922,474.00 | 27,162,943.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,602,574.00 | 3,802,225.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 19,813,200.00 | 23,360,718.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 506,700.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 43,843,254.00 | 66,394,287.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,376,700.00 | 4,235,787.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,013,428.00 | 46,828,110.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 762,600.00 | 1,588,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,600,526.00 | 964,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,090,000.00 | 8,359,100.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 00.00 | 4,418,490.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 41,445,300.40 | 95,375,508.55 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 33,319,500.40 | 83,213,733.55 |
| 210502 | Хоол, хүнс | 7,999,800.00 | 12,161,775.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 126,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,250,000.00 | 3,655,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,250,000.00 | 3,655,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,000,000.00 | 1,642,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,000,000.00 | 1,642,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 81,873,356.00 | 00.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 79,577,956.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,300,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 871,200.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 124,200.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 93,314,416.39 | 97,996,517.08 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,853,325.00 | 16,407,516.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,212,903.00 | 8,865,457.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 1,300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 1,300,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 5,316,626.00 | 7,565,457.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,316,626.00 | 7,565,457.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 896,277.00 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 896,277.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **152,274,702.55** | **-73,659,515.85** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | -3,000.00 | 2,475,000.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 2,475,000.00 |
| 225002 | Найдваргүй авлагын алдагдал | -3,000.00 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 3,000.00 | -2,475,000.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **152,277,702.55** | **-76,134,515.85** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **335,088,772.04** | **631,641,501.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **210,000.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 210,000.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 210,000.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 210,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **334,878,772.04** | **631,641,501.50** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 133,326,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 13,795,700.00 | 35,728,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 13,795,700.00 | 35,728,400.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 187,757,072.04 | 595,913,101.50 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 187,757,072.04 | 595,913,101.50 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **232,876,785.89** | **660,821,792.31** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **232,876,785.89** | **660,821,792.31** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **232,876,785.89** | **651,956,335.31** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 85,874,093.55 | 410,632,877.43 |
| 210101 | Үндсэн цалин | 56,126,994.25 | 222,658,603.37 |
| 210102 | Нэмэгдэл | 20,822,863.30 | 145,837,799.44 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,197,000.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 7,727,236.00 | 42,136,474.62 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 11,310,707.34 | 57,006,292.88 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,844,856.43 | 37,458,093.12 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 922,924.28 | 4,886,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 694,659.46 | 3,909,899.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 168,024.31 | 977,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,680,242.86 | 9,773,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,083,922.00 | 27,162,943.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 663,494.00 | 3,802,225.00 |
| 210302 | Түлш, халаалт | 10,353,728.00 | 23,360,718.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 66,700.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,110,440.00 | 56,761,810.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 530,000.00 | 2,701,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,752,440.00 | 45,328,110.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 1,479,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 662,000.00 | 1,580,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 166,000.00 | 5,671,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 11,431,900.00 | 72,449,996.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 9,165,900.00 | 58,772,646.00 |
| 210502 | Хоол, хүнс | 2,266,000.00 | 10,727,350.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 2,950,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 375,000.00 | 8,832,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 2,000,000.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 880,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 375,000.00 | 5,952,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 1,642,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 1,642,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 101,426,723.00 | 00.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 101,426,723.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 264,000.00 | 17,468,416.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 264,000.00 | 17,468,416.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **00.00** | **8,865,457.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 1,300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 1,300,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 7,565,457.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 7,565,457.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **102,211,986.15** | **-29,180,290.81** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **31,000,000.00** | **21,300,208.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **31,000,000.00** | **21,300,208.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 31,000,000.00 | 21,300,208.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 31,000,000.00 | 21,300,208.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-31,000,000.00** | **-21,300,208.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 89,156,563.55 | 38,676,064.74 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 89,156,563.55 | |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 38,676,064.74 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 734,316,565.92 | 204,431,933.30 | -240,322,183.66 | 00.00 | 698,426,315.56 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **734,316,565.92** | **204,431,933.30** | **-240,322,183.66** | **00.00** | 698,426,315.56 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 149,656,549.12 | 00.00 | 149,656,549.12 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **734,316,565.92** | **354,088,482.42** | **-88,044,481.11** | **00.00** | 1,000,360,567.23 |
| D01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **734,316,565.92** | **354,088,482.42** | **-88,044,481.11** | **00.00** | 1,000,360,567.23 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **734,316,565.92** | **354,088,482.42** | **-88,044,481.11** | **00.00** | 1,000,360,567.23 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -76,134,515.85 | 00.00 | -76,134,515.85 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **734,316,565.92** | **354,088,482.42** | **-164,178,996.96** | **00.00** | 924,226,051.38 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 861,403,600.00 | 674,556,543.31 | 186,847,056.69 | 78.3 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 861,403,600.00 | 674,556,543.31 | 186,847,056.69 | 78.3 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 859,903,600.00 | 673,256,543.31 | 186,647,056.69 | 78.3 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 535,741,800.00 | 410,632,877.43 | 125,108,922.57 | 76.6 |
| 210101 | Үндсэн цалин | 270,905,400.00 | 222,658,603.37 | 48,246,796.63 | 82.2 |
| 210102 | Нэмэгдэл | 205,251,900.00 | 145,837,799.44 | 59,414,100.56 | 71.1 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,960,000.00 | 00.00 | 3,960,000.00 | 0.0 |
| 210104 | Урамшуулал | 55,624,500.00 | 42,136,474.62 | 13,488,025.38 | 75.8 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 66,967,700.00 | 57,006,292.88 | 9,961,407.12 | 85.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,258,100.00 | 37,458,093.12 | 7,800,006.88 | 82.8 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,427,400.00 | 4,886,900.00 | 540,500.00 | 90.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,342,000.00 | 3,909,899.76 | 432,100.24 | 90.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,085,400.00 | 977,600.00 | 107,800.00 | 90.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,854,800.00 | 9,773,800.00 | 1,081,000.00 | 90.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34,728,400.00 | 27,162,943.00 | 7,565,457.00 | 78.2 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,335,400.00 | 3,802,225.00 | 1,533,175.00 | 71.3 |
| 210302 | Түлш, халаалт | 29,169,000.00 | 23,360,718.00 | 5,808,282.00 | 80.1 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 224,000.00 | 00.00 | 224,000.00 | 0.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 66,302,300.00 | 56,761,810.00 | 9,540,490.00 | 85.6 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,450,000.00 | 2,701,800.00 | 748,200.00 | 78.3 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 51,330,300.00 | 45,328,110.00 | 6,002,190.00 | 88.3 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,622,000.00 | 1,479,900.00 | 142,100.00 | 91.2 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,674,700.00 | 1,580,500.00 | 2,094,200.00 | 43.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,225,300.00 | 5,671,500.00 | 553,800.00 | 91.1 |
| **2105** | **Нормативт зардал** | 96,968,300.00 | 72,449,996.00 | 24,518,304.00 | 74.7 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 74,157,200.00 | 58,772,646.00 | 15,384,554.00 | 79.3 |
| 210502 | Хоол, хүнс | 12,311,100.00 | 10,727,350.00 | 1,583,750.00 | 87.1 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,500,000.00 | 2,950,000.00 | 7,550,000.00 | 28.1 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 37,825,000.00 | 30,132,208.00 | 7,692,792.00 | 79.7 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 16,100,000.00 | 13,400,000.00 | 2,700,000.00 | 83.2 |
| 210602 | Тавилга | 12,225,000.00 | 10,780,208.00 | 1,444,792.00 | 88.2 |
| 210604 | Урсгал засвар | 9,500,000.00 | 5,952,000.00 | 3,548,000.00 | 62.7 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,450,000.00 | 1,642,000.00 | 808,000.00 | 67.0 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 2,450,000.00 | 1,642,000.00 | 808,000.00 | 67.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 18,920,100.00 | 17,468,416.00 | 1,451,684.00 | 92.3 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,920,100.00 | 17,468,416.00 | 1,451,684.00 | 92.3 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,500,000.00 | 1,300,000.00 | 200,000.00 | 86.7 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,500,000.00 | 1,300,000.00 | 200,000.00 | 86.7 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | 1,300,000.00 | 200,000.00 | 86.7 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 861,403,600.00 | 713,232,544.50 | 148,171,055.50 | 82.8 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 35,728,400.00 | 28,162,943.00 | 7,565,457.00 | 78.8 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 35,728,400.00 | 28,162,943.00 | 7,565,457.00 | 78.8 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 736,518,700.00 | 595,913,101.50 | 140,605,598.50 | 80.9 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 736,518,700.00 | 595,913,101.50 | 140,605,598.50 | 80.9 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 89,156,500.00 | 89,156,500.00 | 0.00 | 100.0 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 89,156,500.00 | 89,156,500.00 | 0.00 | 100.0 |

# 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу хүн амын нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчийн сэтгэл, ханамж, итгэл найдварт нийцүүлэн чанар хүртээмжтэй үзүүлэх чиг үүрэгтэй ЭМЯ-ны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь 2023 онд 23 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд тайлант онд нийт хэвтэн эмчлүүлэгсэд 363, дундаж ор хоног 6.4, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 2,595 хүн хамрагдаж, үүнээс амбулаторийн үзлэгт 808, урьдчилан сэргийлэх үзлэгт 648, бусад үзлэгт 1,139 хүн хамрагдсан байна.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төв нь “Эрүүл мэндийн байгууллагын ажлын хариуцлага, тусламж үйлчилгээний чанарт сөрөг нөлөө, технологийн зөрчил, хариуцлагагүй байдал, ёс суртахууны доголдлыг гаргахгүй байх”, “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулж, хүн амын эрүүл мэндийн бодит байдал, хэрэгцээ шаардлагыг хэтийн төлөвтэй уялдуулан давуу талтай ажиллана”, “Эмнэлгийн барилга, байгууламж, багаж төхөөрөмжийн засвар шинэчлэл хийж, замаар үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх”, “Эмнэлгийн удирдлагын менежментийг боловсронгуй болгож эрүүл мэндийн тусламжийн чанар сайжруулах”, “Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлж, тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлнэ” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Дарга Б.Хоролмаа (2023.01.01-2023.12.31), 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Н.Нямдорж



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

(2023.01.01-2023.04.01), М.Сувдмаа (2023.04.01-2023.06.01), Х.Гантулга (2023.06.01-2023.12.31) нар зурж, нярваар Б.Өлзий-Орших ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль шинээр батлагдаж мөрдөж эхэлсэн.
- Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Төсвийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг мөрдөж ажилласан.
- Засгийн газрын 2023 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоол.
- Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрддөг Баянхонгор аймгийн төсвийн байгууллага, төсөл сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх НББББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

"Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 923,154.2 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 98,662.6 мянган төгрөгөөр буюу 7.9 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* (мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 89,156.6 | 38,676.1 | (50,480.5) |
| Авлага | 1,365.2 | 14,844.5 | 13,479.3 |
| Бараа материал | 165,529.8 | 141,651.1 | (23,878.7) |
| Үндсэн хөрөнгө | 1,024,774.7 | 1,042,593.5 | (17,818.8) |
| Хуримтлагдсан элэгдэл | (259,009.5) | (314,611.0) | (55,601.5) |
| **Нийт хөрөнгө** | **1,021,816.8** | **923,154.2** | **(98,662.6)** |
| Богино хугацаат өр төлбөр | 21,456.2 | 165.7 | (21,290.5) |
| Засгийн газрын хувь оролцоо (Эздийн өмч) | 1,000,360.6 | 922,988.5 | (77,372.1) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,021,816.8** | **923,154.2** | **(98,662.6)** |

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл 38,676.1 мянган төгрөг байгаа нь гүйцэтгэлээр санхүүжилт олгосонтой холбоотойгоор дансны үлдэгдлийг төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 14,844.5 мянган төгрөг байгаа нь төлбөртэй үйлчилгээний авлага 6,685.8 мянга, нийгмийн даатгалын байгууллагад өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн актын авлагыг давхар шилжүүлснээс үүссэн ажиллагсадтай холбогдсон нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 7,689.2 мянга байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 141,651.1 мянган төгрөг болж өмнөх оноос 23,878.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 146,365.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, "Залаа амин дэм" ХХК-иас хандиваар 2,441.4 мянган төгрөгийн бараа материалыг авч, үйл ажиллагаандаа 172,685.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,042,593.5 мянган төгрөг болж 17,818.8 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн Эрүүл мэндийн газраас хуваарилсан 26,218.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, шийдвэрийн дагуу аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2023 оны 66 дугаар захирамжийн дагуу 29,700.0 мянган төгрөгийн хөрөнгийн авто тээврийн хэрэгслийг актлалсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 165.7 мянган төгрөг байгаа нь "Хайрхан фарм" ХХК-д эмийн өглөгийг барагдуулаагүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 77,372.1 мянган төгрөгөөр буурч 922,988.5 мянган төгрөг болсон байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 834,969.4 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийг 35,728.4 мянга, нийт зарлагыг 870,697.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 9,294.2 мянган төгрөгөөр бууруулж улсын төсвийг 825,675.2 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийг 35,728.4 мянган тус тус баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 825,675.2 мянга, орон нутгийн төсвөөс 35,728.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр улсын төсвөөс 685,069.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 140,605.6 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон, орон нутгийн 35,728.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Улсын төсвийн зардлын гүйцэтгэл 646,393.6 мянган төгрөг буюу 94.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 38,676.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

(мянган төгрөгөөр)

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | **Улсын төсөв** | | | | |
| 1 | 71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ | 685,069.6 | 646,393.6 | 38,676.0 | 94.35% |
| 1.1 | 80302 Нэг иргэнд ноогдох норматив | 477,267.3 | 452,758.8 | 24,508.6 | 94.86% |
| 1.2 | 81603 Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 197,107.2 | 183,139.7 | 13,967.4 | 92.91% |
| 1.3 | 83603 Дээд шатны төсвөөс хуваарилсан | 10,695.2 | 10,495.2 | 200.00 | 98.13% |
| | **Орон нутгийн төсөв** | | | | |
| 2 | 71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ | 35,728.4 | 28,162.5 | 7,565.4 | 78.8% |
| 2.1 | 80112 Нийтлэг үйлчилгээ | 35,728.4 | 28,162.5 | 7,565.4 | 78.8% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

#### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 29,169.0 мянга, гэрэл цахилгааны зардалд 5,335.4 мянга, цэвэр, бохир усны зардалд 224.0 мянга, шатахууны зардалд 51,330.3 мянган төгрөг, эм эмнэлгийн хэрэгслийн зардалд 74,157.2 мянга, хоол хүнсний зардалд 12,311.1 мянга, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 10,500.0 мянган төгрөг батлагдаж "Батбогд дулаан" ХХК-тай дулаанаар хангах гэрээ, "Ник" ХХК-тай шатахууны гэрээ, "ЭБЦТС" ТӨХК-тай цахилгаан, эрчим хүчээр хангах гэрээ, "Арын баян ус" ХХК-тай хоол, хүнс нийлүүлэх гэрээ, ЭМДЕГ-тай эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газар нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 105 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсөв 802,800.0 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 802,800.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,042.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,429.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд хуулийн хэрэгжилтийг шалгахад 2023 оны түлш халаалтын зардлыг 5,808.3 мянга буюу 19,9 хувь, гэрэл цахилгааны зардлыг 1,533.2 мянга буюу 28.7 хувь, тээвэр, шатахууны зардлыг 6,002.2 мянга буюу 11.7 хувь, эм эмнэлгийн хэрэгслийн зардлыг 15,384.6 мянга буюу 20.7 хувь, 1,583.7 мянга буюу 12.9 хувиар хэмнэж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2023 онд 159 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 141 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст дулаанаар хангах, шатахуун нийлүүлэх, хүнсний материал нийлүүлэх, хамтран ажиллах, худалдах худалдан авах гэсэн 5 гэрээг байршуулаагүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 28,630.5 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс 21,759.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж, зөрчлийг арилгах 1 албан шаардлага, хариуцлага тооцох 1 албан шаардлага, 6,870.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг биелүүлж ажиллан биелэлтийг Баянхонгор аймгийн даргын 2023 оны 06 дугаар 07-ны өдрийн 48 дугаар албан бичгээр ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 6,870.6 | 1 | 6,870.6 | 100.0% |
| Албан шаардлага | 1 | 0.00 | 1 | 0.00 | 100.0% |
| Хариуцлага тооцох | 1 | 0.00 | 1 | 0.00 | 100.0% |
| Зөвлөмж | 2 | 21,759.9 | 2 | 21,759.9 | 100.0% |
| **Нийт дүн** | **5** | **28,630.5** | **5** | **28,630.5** | 100.0% |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,213.5 мянган төгрөгийн 6 зөрчил[1] илэрснээс, 9,680.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 6,533.5 мянган төгрөгийн 4 албан шаардлага өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 16,213.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 7,784.1 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалтай дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1. Тус байгууллага нь ариутгагчийн сертификатгүй хүнд ариутгагчийн орон тоог хавсарган 40 хувиар тооцон 1,200.0 мянган төгрөг, “Мандал гоо фарм” ХХК-ийн захирал нь тус байгууллагад багийн бага эмчээр давхар ажил эрхэлдэг бөгөөд тус албан хаагчид бүтэц орон тоонд батлагдаагүй тендерийн эм хариуцсан ажилтныг хавсарган 40 хувиар тооцон 1,686.6 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Тайлант хугацаанд зориулалт бусаар зарцуулсан 2,886.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2. Тайлант хугацаанд 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг давхардуулан шилжүүлснээс нийгмийн даатгалын байгууллагад 6,793.4 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх “Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ”, 17.1.1 дэх “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Нийгмийн даатгалын хэлтэст үүсгэсэн авлагыг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**5.2 Албан шаардлага**

5.2.1. Бараа материалын тайланд "Лхагүн" ХХК-иас худалдан авсан 5,670.2 мянган төгрөгийн бараа материалыг орлого авалгүйгээр шууд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Бараа материалын тайланд тусгалгүй зарцуулсан хөрөнгийг тайланд тусгах, эмийг тайланг нөхөн гаргаж зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй албан шаардлагыг өгөв.

5.2.2. Сувилагч Г.Батгэрэлийн 2023 оны 8 дугаар сарын амралтын цалинг нийгмийн даатгалд мэдээлэхдээ 863.3 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ", 17.1.1 дэх "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Нийгмийн даатгалын хэлтэст цалин түүнтэй адилтгах орлогыг 863.3 мянган төгрөгийг нөхөн мэдээлж, тооцоо нийлж баталгаажуулах албан шаардлага өгөв.

5.2.3. Шинэжинст сумын Эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд эмийн тайланг гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Эмийн тайланг нөхөн гаргах, цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.2.4. Тайлант онд шилэн дансны цахим хуудаст дулаанаар хангах, шатахуун нийлүүлэх, хүнсний материал нийлүүлэх, хамтран ажиллах, худалдах худалдан авах гэсэн 5 гэрээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх орхигдуулсан мэдээллийг байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэх албан шаардлагыг өгөв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тус байгууллага нь ариутгагчийн сертификатгүй хүнд ариутгагчийн орон тоог хавсарган 40 хувиар тооцон 1,200,000 төгрөг, "Мандал гоо фарм" ХХК-ийн захирал нь тус байгууллагад багийн бага эмчээр давхар ажил эрхэлдэг бөгөөд тус албан хаагчид бүтэц орон тоонд батлагдаагүй тендерийн эм хариуцсан ажилтныг хавсарган 40 хувиар тооцон 1,686,647 төгрөгийг олгосон байна. | 1 | 2,886.6 | 1 | 2,886.6 | - | - | - | - |
| Тайлант хугацаанд 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг давхардуулан шилжүүлснээс нийгмийн даатгалын байгууллагад 6,793.4 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна. | 1 | 6,793.4 | 1 | 6,793.4 | - | - | - | - |
| Бараа материалын тайланд "Мандал гоо фарм" ХХК-иас худалдан авсан 5,670.2 мянган | 1 | 5,670.2 | - | - | 1 | 5,670.2 | - | - |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| төгрөгийн бараа материалыг орлого авалгүйгээр шууд зардлаар тайлагнасан байна. | | | | | | | | |
| Сувилагч Г.Батгэрэлийн 2023 оны 8 дугаар сарын амралтын цалинг нийгмийн даатгалд мэдээлэхдээ 863.3 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна. | 1 | 863.3 | - | - | 1 | 863.3 | - | - |
| Тайлант хугацаанд тус байгууллагын нярав нь тендерийн эмийн тайланг гаргасан боловч больницын эмийн тайланг гаргаагүй байна. | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| **Дүн** | **6** | **16,213.5** | **3** | **9,680.0** | **3** | **6,533.5** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант онд шилэн дансны цахим хуудаст дулаанаар хангах, шатахуун нийлүүлэх, хүнсний материал нийлүүлэх, хамтран ажиллах, худалдах худалдан авах гэсэн 5 гэрээг байршуулаагүй байна. | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| Дүн | 1 | - | - | - | 1 | - | - | - |

-----------оОо-----------

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр | Дугаар 42/А057/121 БНА-2024/121/НД-СТА-ТШЗ | Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь ариутгагчийн сертификатгүй хүнд ариутгагчийн орон тоог хавсарган 40 хувиар тооцон 1,200,000 төгрөг, "Мандал гоо фарм" ХХК-ийн захирал нь тус байгууллагад багийн бага эмчээр давхар ажил эрхэлдэг бөгөөд тус албан хаагчид бүтэц орон тоонд батлагдаагүй тендерийн эм хариуцсан ажилтныг хавсарган 40 хувиар тооцон 1,686,647 төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажил хавсарсны нэмэгдэлд олгосон 2,886,647 (хоёр сая найман зуун наян зургаан мянга зургаан зуун дөчин долоо) төгрөгийг төсвийн захирагч, нягтлан

5050183

бодогч нараар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх[1]

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Хоролмаа, нягтлан бодогч А.Даваасүрэн нарт даалгав[2].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БАТЧИМЭГ

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 43/А0571121 БНА-2024/121/НА-СТА-ТШЗ Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг давхардуулан шилжүүлснээс нийгмийн даатгалын байгууллагад 6,793,412 төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх “Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ”, 17.1.1 дэх “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нийгмийн даатгалын байгууллагад давхар шилжүүлж авлага үүсгэсэн 6,793,412 (зургаан сая долоон зуун ерэн гурван мянга дөрвөн зуун арван хоёр)

5050184

төгрөгийг 2024 оны төсвөөс төлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх[1]

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Хоролмаа, нягтлан бодогч А.Даваасүрэн нарт даалгав[2].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БАТЧИМЭГ

---

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 75/АС571/21
БНА-2024/121/НА-СТА-ТШ3

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын тайланд “Лхагүн” ХХК-иас худалдан авсан 5,670,200 төгрөгийн бараа материалыг орлого авалгүйгээр шууд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалыг орлого авч бүртгэн зөрчлийг арилгаж, биелэлтийг нотлох баримтын хамт 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

5040273

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Хоролмаа, нягтлан бодогч А.Даваасүрэн нарт даалгав .

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[1]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БАТЧИМЭГ

---

[1] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 23 өдөр                Дугаар 76/А057/121/ БНА-2024/121/НА-СТА-ТШ3                Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинэжинст сумын Эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд эмийн тайланг гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

5040274

1. Эмийн тайланг нөхөн гаргах, зөрчлийг арилгаж, биелэлтийг нотлох баримтын хамт 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Хоролмаа, нягтлан бодогч А.Даваасүрэн нарт даалгав .

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[1]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БАТЧИМЭГ

[1] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 77/A0571121 БНА-2024/121/НА-СТА-ТШЗ Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сувилагч Г.Батгэрэлийн 2023 оны 8 дугаар сарын амралтын цалинг нийгмийн даатгалд мэдээлэхдээ 863,340 төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх “Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ”, 17.1.1 дэх “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн даатгалын хэлтэст цалин түүнтэй адилтгах орлогыг 863,340 төгрөгийг нөхөн мэдээлж, тооцоо нийлж баталгаажуулан зөрчлийг арилгаж, биелэлтийг нотлох баримтын хамт 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

5040279

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Хоролмаа, нягтлан бодогч А.Даваасүрэн нарт даалгав .

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[1]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БАТЧИМЭГ

[1] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр    Дугаар Т8/А05711/21 БНА-2024/121/НА-СТА-ТИ23    Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст дулаанаар хангах, шатахуун нийлүүлэх, хүнсний материал нийлүүлэх, хамтран ажиллах, худалдах худалдан авах гэсэн 5 гэрээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасны дагуу дулаанаар хангах, шатахуун нийлүүлэх, хүнсний материал нийлүүлэх, хамтран ажиллах, худалдах худалдан авах гэсэн 5 гэрээг бүрэн байршуулан зөрчлийг

5040280

арилгаж, биелэлтийг нотлох баримтын хамт 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Хоролмаа, нягтлан бодогч А.Даваасүрэн нарт даалгав .

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[1]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БАТЧИМЭГ

[1] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно